

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-ЫН  
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ  
/2021 оны 01 дүгээр улирлын байдлаар/

2020 оны 03 дугаар сарын 22

Багануур дүүрэг

Д/д	Өргөдөл, гомдлын агуулга	Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэх шатандаа байгаа		Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо					Иргэнд хариу хүргүүлсэн хэлбэр			Өргөдлийн төрөл				
			Шийдвэрлэх хугацаандаа байгаа	Хугацаа хэтэрсэн	1-10 хоногт	11-20 хоногт	21-30 хоногт	Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тоо	Албан бичгээр	Утсаар	Биечлэн уулзах	Талархал	Санал	Хүсэлт	Гомдол	Мэдэгдэл
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Ажил хүссэн	1			1							+			+		
2	Дэмжлэг туслалцаа хүссэн																
3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой																
4	Тухайн байгууллагын ажилтан, албан хаагчдаас гаргасан өргөдөл	1			1							+			+		
5	Иргэдээс байгууллагын ажилтан, албан хаагчидтай холбоотой гаргасан өргөдөл																
6	Бусад																
	Нийт	2			2							2			2		

**Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал**

№	Ангилал	Тоо	Шалтгаан, тайлбар
0	1	2	3
1	Иргэний талд шийдвэрлэсэн өргөдөл	5+1+3	- “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т жолооч ажилтай Намсрайн Жаргалсайханы ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. - “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-т жолоочоор ажиллаж байсан Дамбачимэдийн Бат-Эрдэнэ Хэнтий аймгаас нүүн ирж эргээд ажиллах боломжтой болсон тул ажилд орох хүсэлт гаргасан.
2	Боломжгүй тухай хариу өгсөн	-	-
3	Бусад	-	-

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ-Т ИРГЭД,  
АЛБАН ХААГЧДААС ГАРГАСАН ӨРГӨДЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2021 оны 03 дугаар сарын 19

Багануур дүүрэг

Манай байгууллагад 2021 оны 01 дүгээр улиралд иргэдээс ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх утгатай 2 өргөдөл ирсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал өргөдөл хүсэлтийн төрлийн хувьд адилхан, тооны хувьд цөөн байна. Тухайлбал, өнгөрсөн оны 1 дүгээр улирлын байдлаар манай байгууллагад 5 өргөдөл ирсэн байна. Үүнд: 2 иргэнээс ажилд орох хүсэлт, 2 ажилтан ажлаас чөлөөлөгдөх, 1 ажилтан тэтгэвэрт гарах болсны улмаас ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг тус бүр “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨТҮГ-ын даргын тушаалаар хүсэлтийн дагуу өдөр, өдөрт нь багтаан шийдвэрлэсэн.

Дээрх өргөдлүүдийг ERP системийн Өргөдөл, гомдол дэд хэсэгт бүртгэж, өргөдөл хяналтын картыг хөтөлж, өргөдлүүд болон өргөдөл хяналтын картаар хадгаламжийн нэгж үүсгэн тус тус архивласан.


Өргөдлийг хамгийн боломжит богино хугацаанд шийдвэрлэхийг зорьж байгаа бөгөөд ажлын 1 өдрийн дотор шийдвэрлэж байна.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.


Бүтээлч санал санаачилгын шинжтэй хүсэлт илэрхийлж, мэдээлэл хүссэн иргэдтэй байгууллагын удирдлага биечлэн уулзаж, Паркийн зорилго чиглэл, үйл ажиллагааны тухай тодорхой мэдээлэл, зөвлөгөө, чиглэл өгч ажилладаг. Энэ уулзалтын бүртгэлийг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр албан бичгээр хүргүүлдэг. Иргэд, аж ахуйн нэгжээс гаргасан бүтээлч санал санаачилгын хүсэлтийг Паркийн үйл ажиллагаатай уялдуулан нааштайгаар шийдвэрлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах зорилгыг хэрэгжүүлэн ажиллаж байгаагийн нэг илрэл нь Багануур дүүрэгт төмрийн үйлдвэр барих төсөл хэрэгжүүлж байгаа МЕСЕС ХХК-тай 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан гэрээ байгуулан ажиллаж байгаа явдал юм. Энэ ажлын хүрээнд Паркийн цахилгаан хангамжийн 110кВ-ын өндөр хүчдэлийн 7,3км урт агаарын шугам болон үндсэн дэд станц болох 110/35кВт-ын зураг төслийг ЭХЯ-наас олгосон техникийн нөхцөлийн дагуу боловсруулж Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-тай зөвшилцөж, нэмэлт өөрчлөлтийг оруулан баталгаажуулж байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэгт 2018 оноос эхлэн улирал бүр нээлттэй байршуулан ажиллаж байна.

Иргэдээс манай байгууллагын ажилтан, албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол байхгүй.

ХЯНАСАН:   
“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
ПАРК” ОНӨТҮГ-ЫН ДАРГА

Ч.ЭЛБЭГСАЙХАН

ТАЙЛАН ГАРГАСАН:   
АРХИВ, БИЧИГ ХЭРЭГ, ГАДААД  
ХАРИЛЦАА ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.МӨНХДУЛАМ